

**С.БУЯННЭМЭХИЙН НАМТАР ДАХЬ ЗАРИМ
ЭНДҮҮРЛИЙГ АРИЛГАХ АСУУДАЛД**

Ван Мандуга*

Товч агуулга: Өгүүлэлд ховор цухаг архивийн материал болон баялаг текст материалд тулгуурлан зохиолч С.Буяннэмэхийн намтар дахь зарим эндүүрлийг зөвтгөн засахыг хичээсэн байна. Олон зүйлийн бусудчи/субектив/ ба биеч шалтгаанаас болж, гадаад дотоодын монгол уран зохиолын түүхчид, судлагчид өөрийн ном зохиолдоо С.Буяннэмэхийн намтар бүтээлийн тухай хазгай буруугаар, цаашилбал зарим нь мушгин гуйвуулж гажуудуулан бичиж тэмдэглэсэн нь цөөн бус харагдана. Тус өгүүлэлд түүхэн үнэний мөрөөр хянуур лавдуун тунгаалт хийж, алдаа мэдгий нь ариутган залруулахаар мэрийжээ.

Түлхүүр үг: С. Буяннэмэх, намтар бүтээл, уран зохиолын түүх

Нэг

Зохиолч Сономбалжирын Буяннэмэх 1937 оны 9-р сарын 10-ны өдөр хувьсгалын эсэргүү бүлгэмийн гишүүн хэмээх хилс хэргээр баривчлагдаж, тус жилийн 10-р сарын 25-ны өдрийн БНМАУ-ын Улсын бага хурлын тэргүүлэгчдийн ардын сайд нарын зөвлөлийн ерөнхий сайд, ерөнхий сайдын нэгдүгээр орлогч нарын хамтарсан онц хурлаас томилогдсон онцгой бүрэн эрхт комиссын нэгдүгээр хурлын тогтоолоор шүүхийн дээд хэмжээгээр шийтгүүлжээ.

С. Буяннэмэх нь Гэндэн, Дэмидийн хувсгалын эсэргүү бүлгэмийн гишүүн, ардын дайсан, Японы тагнуул хэмээх улс төрийн хилс хэрэгт өртөгдөж амь эрсдсэнээс 25 жилийн дараа, даруй 1962 оны 11-р сарын 16-ны өдрийн БНМАУ-ын дээд шүүхийн бүгд хурлын 017-р тогтоолоор хилсийг нь цагаатгаж, нэр хүндийг нь сэргээн өгчээ. Энэхүү 25 жилийн урт хугацаанаа зохиолч С.Буяннэмэхийн бүх зохиол бүтээл нь “Эсрэгүүгийн зохиол учраас бүрмөсөн шатаан устгах” хар дансанд жагсаагдаж, нийт олны дунд тархан дэлгэрч, уншин сонирхогдож, шинжлэн судлагдах бүх боломжоо алдсан байжээ.

Утга зохиол судлагч Балданы Содномын бичсэн “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв”(1) хэмээх бүтээлийн “Тусгаар тогтносон Монгол Ард Улсын утга зохиол” хэмээх гуравдугаар хэсэгт 1921-1946 он хүртлэх Монголын шинэ уран зохиолыг тоймчлон авч үзсэн боловч С.Буяннэмэхийн намтар, уран бүтээлийн тухай яриагүй орхигдуулжээ. Харин

* БНХАУ-ын Төвийн Үндэсний их сургуулийн Монгол хэл утга зохиолын салбар

түүний бичсэн “Са ндо Амбаны харгис явдал” (2) , “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв”(3), “Улаан туг”(4) зэрэг уран бүтээлийн тухай цухас дурдсан боловч зохиолчийн нэрийг дурдалгүй өнгөрчээ.

Утга зохиол судлагч Орос улсын Г. И. Михайлов, түүний 1955 онд бичсэн “Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал”(5) гэдэг номдоо зохиолч С.Буяннэмэхийг хувсгалын эсрэгүү ардын дайсан хэмээн ахин дахин нухлан шүүмжилж, дарамтлан үгүйсгэсэн байна. Энд хэдэн жишээг сийрүүлвэл, “Тайзан дээр Хятадын шалиг явдалт жүжгийг тавьж, хэвлэлийн хуудсан дээр Хятадын хуучин тууж новелийн нөлөөг шингээсэн Буяннэмэх, Ядамсүрэн нарын бүлгийн зохиолчдийн зохиол гарч байжээ”(6), “... Монголын ард түмэнд харш урлагийг дэлгэрүүлэхийг хичээж байсан Ядамсүрэн, Буяннэмэх нар, тэдний талынхны хорлох үйл ажиллагааг бодолцвол үндэсний хэлбэрийн шаардлага, ялангуяа тэр үед маш их учир утгатай байв”(7), “... Эсэргүү лагерийн зохиолчид, тэдний их нэр алдартай төлөөлөгч Ядамсүрэн, Буяннэмэх, Ш.Аюуш зэрэг хүмүүс феодализмыг довтлох явдлыг саатуулах, олон түмний дотор феодалын ба хөрөнгөтний - үндэсний явцуу үзэл суртлыг нэвтрүүлэхийг бүх хүчээрээ чармайж байв”(8), “Буяннэмэх өөрийн болхи шүлэгт Чингис хааныг алдаршуулах буюу уншигчдийг чухал асуудлаас “дан урлагийн” талд чирч аваачихийн тулд танин мэдэхүй, хүмүүжүүлэх ач холбогдол байхгүй, зарчимгүй зохиолыг бичиж байв”(9), “ Буяннэмэх ба түүний нэг санаатнууд театрт үйл ажиллагаагаа дэлгэрүүлж, театрын тайзан дээр дуут шалиг жүжиг тоглуулж байв”(10), “Буяннэмэх, Ядамсүрэн нарын лагерийн шүлэгчид, яруу найргийн бүтээлийн ерийн хэлбэрээр хангагдсангүй, үнэн хэрэгтээ хэлбэр баримталсан төрөл бүрийн гоёмсоглож дур мэдэн гайхуулах явдалд гүйж очигцоов. Тэгээд гучаад онд асуулт хариултын тусгай төрлийн шүлгүүд гаргажээ...”(11), “1937-1938 онуудад Монгол Ардын Хувьсгалт намаар манлайлуулсан ард түмэн, Японы эзэрхэг түрэмгийтний хөлсний зарц шар зөгийн үүрүүдийг устгахад Буяннэмэх, Ядамсүрэн нарын лагерь бүрмөсөн устгагджээ” (12) , “... Ядамсүрэн, Буяннэмэх зэргийн хөрөнгөтний үндэсний үзэлтний бүлгийг арилгасны дараа жүжгийн зохиолд том дэвшилт гарсныг гэрчилж байна... Буяннэмэх, Ядамсүрэн, Ш.Аюуш тэдний нөлөөнд орсон зохиогчдийн үл бүтэх шалиг самууныг эрхэмлэн гаргасан үзэл сурталгүй хэлбэр голлосон зохиолууд, театрт ийм боломж урьд нь өгөөдгүй байжээ”(13), “1934 онд Д. Нацагдоржийн зохиосон “Учиртай гурван толгой” гэдэг аялгуут жүжгийг тоглосон байна. Энэ жүжиг Буяннэмэх, Ядамсүрэн, Ш.Аюуш, Раднаабазар нарын сентименталист дуут жүжгүүд ба натуралист жүжгүүдийн эсрэг зогсчээ”(14)... гэх мэтчлэн С.Буяннэмэх, М.Ядамсүрэн, Ш.Аюуш зэрэг зохиолчдийг “Буяннэмэх, Ядамсүрэн нарын бүлэг”, “Эсэргүү лагерийн зохиолчид”, “Хөрөнгөтний үндэсний үзэлтний бүлэг”, “Японы эзэрхэг түрэмгийлэгчдийн хөлсний зарц шар зөгийн үүр” гэх мэтээр заналхийлан дайрч, зохиол бүтээлийг нь “Шалиг явдалт жүжиг”, “Болхи шүлэг”, “танин мэдхүй, хүмүүжүүлэх ач холбогдол байхгүй, зарчимгүй зохиол”, “дуут шалиг жүжиг”, “хэлбэр баримталсан төрөл бүрийн гоёмсоглож дур мэдэн гайхуулах зохиол”, “үл бүтэх шалиг самууныг эрхэмлэн гаргасан үзэл сурталгүй хэлбэр голлосон зохиол”, “сентименталист дуут жүжиг”, “натуралист жүжиг”... гэх мэтээр зүйл зүсмийн нэр титэм зүүлгэж, гүжирдэн муушаасан байна. Үүгээр барахгүй ямар ч үндэс баримтгүй, худал зохиомол хэрэг тулгаж, ангич чанар, намч чанарын хязгаарлашгүй өндөр зарчмын үүднээс ташуурдан шүүмжилжээ. Жишээлбэл, С.Буяннэмэх нарыг “ард түмэнд харш урлагийг дэлгэрүүлэх”, “хорлох үйл ажиллагаа”, “феодализмыг довтлох явдлыг саатуулах, олон түмний дотор феодалын ба хөрөнгөтний - үндэсний явцуу үзэл суртлыг нэвтрүүлэх”, “Чингис хааныг алдаршуулах”, “уншигчдийг чухал асуудлаас “дан урлагийн” талд чирч аваачих”, “ард түмнийг дайсагнасан” гэх мэтийн хувьсгалд харштай, ард түмэнд харштай, үндсэрхэг үзэлтэй эсэргүү зохиол бүтээлийг зохион туурвиж, хувьсгалын эсрэг эвдэн сүйтгэх үйл ажиллагаа

Ван Мандуга

хийж байсан гэж хайр гамгүйгээр гүтгэжээ. Судлагч Г.И.Михайлов тухайн үеийн нийгэм түүх, улс төрийн байдалд хэтэрхий нөлөөлөгдөж “Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал” номдоо “Монголын орчин үеийн уран зохиолын үүсэл хөгжлийн тухай бодит үнэн байдлыг зориуд гажуудуулж, түүхэн үнэнээс хэт тасархай дүн шинжилгээ хийжээ”. “Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал”-даа зохиолч С.Буяннэмэхийн бичсэн “Улаан туг”, “Интернационал”, “Сандо Амбаны харгис явдал” (Сандо Амбан - зохиогч), “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв” мэтийн бүтээлүүдийг дурдсан боловч зохиогчийн нэрийг нь тодорхойлсонгүй орхижээ.

Б.Содном хийгээд Г.И.Михайлов хоёрын дээр дурдсан бүтээл нь зохиолч С.Буяннэмэхийг иргэний талаас цагаатгаж өгөхөөс өмнө бичигдсэн тул тухайн үеийн нийгэм түүх, цаг үеийн байдлаас болж түүний монголын орчин үеийн уран зохиолын гол нэгэн үндэслэгч болох, ууган зохиолч, онол шүүмжлэгч, улс төр, олон нийт, соёлын томоохон зүтгэлтэн болох түүхэн байр суурийг төв голч, үнэн мөнөөр үнэлэн цэгнэх боломжгүй байсан билээ. Ийм учраас бид энэ хоёр номоос С.Буяннэмэхийн намтар уран бүтээлийн тухай зөб талийн ямар ч мэдээлэл, ямар ч ойлголтыг олж чадахгүй юм.

Хоёр

1962 онд С.Буяннэмэхийн улс төрийн хилсийг цагаатган өгч, нэр төрийг нь сэргээснээс сүүлээр, түүний намтар уран бүтээлийг судлах ажил аажмаар сэргэж эхэлжээ.

Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн П.Хорлоо, С.Лувсанвандан, Ц.Мөнх, Д.Цэнд нарын найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх”(1921-1965)(15)-д С.Буяннэмэхийн тухай ингэж тэмдэглэжээ: “Буяннэмэх 1902 онд тэр үеийн Түшээт хан аймгийн Говь Түшээ гүнгийн хошуу, одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг Онгийн голын бэлчирт малчин ард эмэгтэй Думаагийн гэрт төржээ. Сономбалжирийн амьдрал тусгай байсан учир эх Думаагийн гар дээр хүмүүжиж байгаад таван настай өнчрөн хоцорсон байна. Өнчин хүүт хүргэн ах цахар Лувсан өсгөн хүмүүжүүлж байгаад амьдралын эрхээр есөн настайд нь Тогтох тайжийнд үрчлүүлжээ. Тогтох тайжийнд есөн жил байхдаа Эрдэнэ зэрэг хүмүүсээр монгол, хятад бичиг заалгаж байгаад улмаар Автономитын үеэс дунд сургуульд орж, үндэсний бичгээс гадна орос, хятад хэл заалгаж байжээ. С.Буяннэмэх багын сэргэлэн авхаалжтай, идэвх оролдлоготой байсан тул үндэсний хэлээр болон хятад, манж хэлээр дорно дахины сонгодог зохиолуудыг уншиж байжээ”.

Мөн Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн С.Лувсанвандан тэргүүлсэн Л.Түдэв, Д.Цэдэв, Ц.Мөнх, Д.Цэнд, Ш.Цэнд-Аюуш, Ч.Билэгсайхан, Д.Дашдорж, С.Дашдондог, Г.Жамсранжав, Д.Өлзийбаяр, Ч.Жачин нарын хамтран найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” тэргүүн боть (1921-1940)-д: “Зохиолч Буяннэмэх 1902 онд хуучин Түшээт хан аймгийн Говь Түшээ гүнгийн хошуу, одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт малчин ард эмэгтэй Думаагийн гэрт төржээ. С.Буяннэмэх таван настай байхад эх нь нас барж Лувсангийн өргөгдөж улмаар нагац эцэг нь Тогтох тайжийнд үрчлүүлжээ. Буяннэмэх есөн наснаас Ашингаа зэрэг хүмүүсээр бичиг заалгаж тэр үеийн гэрийн боловсролтой болжээ. Улмаар хэд хэдэн хэл үзэж, ном зохиолоос уншиж эхэлжээ. Улмаар Да хүрээний дунд сургуульд орж эх хэлээс гадна орос хэл заалгасан байна. Тэрээр бага наснаас дорно дахины сонгодог утга зохиол, монгол ардын аман зохиолын бүтээлтэй танилцаж, үндэсний хөгжимд суралцжээ”(16) гэж бичжээ.

Тус хоёр уран зохиолын түүхэд зохиолч С.Буяннэмэхийн төрсөн он, нутаг ус, эцэг эх, өргөж

Ван Мандуга

үрчилсэн хүмүүс, хүртсэн сурган хүмүүжил, амьдралын анхны алхам зэргийг их төлөв тоймчлон тушаасан бөгөөд хоёр ном хоорондоо онцын их зөрөөгүй байна. Гэхдээ хоёр номын зохиогчид зохиолч С.Буяннэмэхийн намтрыг тоймчлон бичихдээ түүхэн үнэний мөрөөр, бат нот баримт материал эзэмшихийг үндэс болгосонгүй, хянуур лавдуун, шинжлэх ухаанч овроор судлагдахуундаа үл хандсан учир, түүхэн үнэнээс гажсан алдаануудыг гаргажээ. Харамсалтай нь хожмын судлагчид (зохиогч ч багтана) С.Буяннэмэхийн намтар бүтээлийн тухай судлахдаа мөн хянамгайгүй овроор хандсан учраас дээрх алдааг үе үеийн хүмүүс дараа дараагаар давтсан байгаа юм. Энэ хэдийгээр ялимгүй жижиг асуудал шиг боловч уран зохиолын түүх бичихэд эрхиш хатуу баримталж, даган мөрдөх шаардлагатай байдаг “түүхийн үнэнээр нь оновчтой бичих” чухал зарчмыг зөрчсөн явдал болохоороо анхаарууштай байгаа юм. Нэн дурдууштай нь иймэрхүү алдааг одоо бас цөөн бус судлаачид давтсаар байгаа нь сэтгэл эмзэглэлтэй.

Гурав

С.Буяннэмэх чухам аль онд төрсөн бэ? Дээр дурдсан хоёр “Түүх”-д бүр 1902 онд төрсөн гэж тэмдэглэжээ. Хожмын хүмүүс олонх нь бүр энэ эндүүрлийг давтаж, ном зохиолдоо ингэж бичиж тэмдэглэх болсон бөгөөд Монгол улсад бараг л албан ёсоор баталсан мэт болж, С.Буяннэмэх 1902 онд төрсөн гэж нийтээрээ мэдрэх болжээ. Жишээлбэл, 1992 онд мэндэлснийх нь 90 жилийн ойг тэмдэглэв. 2002 онд мэндэлснийх нь 100 жилийн ойг өргөн хэвчээгээр тэмдэглэж, аль олон арга хэмжээ авчээ. Үүнд төрсөн бууцанд нь боржин чулуун гэрэлт хөшөө босгов. Дундговь аймгийн төв Мандалговьд дурсгалын хөшөө босгов. Дундговь аймгийн номын санг С.Буяннэмэхийн нэрэмжит болгов. Эрдэнэтийн хивсийн үйлдвэрээс С.Буяннэмэхийн зурагтай ханын хивсийг үйлдвэрлэв. Монгол зохиолчдийн эвлэл болон Дундговь аймгийн засаг даргын тамгийн газар жил бүр олгох С.Буяннэмэхийн шагналыг бий болгов. Мэндэлснийх нь 100 жилийн ойд зориулсан “Буяннэмэхийг дурсахуй”(17) номыг хэвлүүлэв. 2012 онд мэндэлснийх нь 110 жилийн ойг дурсан тэмдэглэхээр төлөвлөж байгаа нь гарцаагүй. Гэтэл аль олон бодит баримт, түүхийн материал нь С.Буяннэмэх бол 1901 онд төрсөн гэдгийг маргашгүй баталж байна.

Баримт нэг. С.Буяннэмэх 1937 оны 9-р сарын 10-ны өдөр хувьсгалын эсэргүү улс төрийн хэрэгт холбогдон баривчлагдаж, 9-р сарын 11-ны өдөр өгсөн анхны мэдүүлэгтээ: “1. нэр: Буяннэмэх 2. овог: Сономбалжир 3. нас: 36 4. төрсөн газар: Өмнөговь аймгийн нутаг Дэлгэрхангайд төрсөн. 5. захиргаа: хотын жинхэнэ хараат, 3-р хороо 6. анги, язгуур угсаа гарал: ард, Халх 7. ямар ямар хэл бичиг мэдэх: Хятад хэл муу мэдэх ба Орос хэл сайн мэдмүй, монгол бичиг сайн мэдмүй. 8. юу юуны гишүүн болох: нам ба хоршоо, улсыг батлан хамгаалахын гишүүн. 9. урьд цагаан ба гэмингийн цэрэгт явсан эсэх: яваагүй. 10. Улаан цэрэгт явж байсан эсэх: үгүй. 11. мэргэжсэн ажил юу болох: Бичгийн ажилд сайн. 12. гэрийн дотор ам хэд болох: Эхнэр Халтархүү, эхнэрийн эцэг Цэрэн нарын хамт гурвуул болно. 13. хөрөнгө чинээ юу болох: хашаа 1, байшин 1, эсгий гэр 1, өөр хөрөнгөгүй ... ” гэж мэдүүлээд, дараа нь “Биеийн хувь түүхийн тухай” ингэж мэдүүлжээ: “Миний бие 1901 онд Дэлгэрхангай хэмээх газар Сономбалжирийн нэгдүгээр хөвүүн болж төрсөн бөгөөд 10 настай Тогтох тайжийнд зарагдаж байхдаа дотоод монголын Эрдэнэ гэгч хүнээр монгол ном анх заалгаж бага зэрэг төсөөлж Автономийн үед дунд сургуулийн сурагчаар орж 2 жил шахам явж монгол бичиг ба орос, хятад хэл нэлээд сайн сурсан болой...”(18) . Энэ бол С.Буяннэмэхийн төрсөн оныг мадаггүй баталж чадах бат нот хөдлөшгүй баримт болох юм. “нас: 36” гэдэг нь бүхэл 36 настай гэсэн үг, “1901 онд Дэлгэрхангай хэмээх газар Сономбалжирийн нэгдүгээр хөвүүн болж төрсөн” гэж өөрийнхөө төрсөн оныг яах аргагүй үнэн зөвөөр мэдүүлсэн байгаа бишүү? Ер нь үүнд сэжиглэх газар бас байна гэж үү?

Баримт хоёр. БНМАУ-ын Дотоод явдлын яамнаас 1937 оны 9-сарын 25-ны өдөр хийсэн “С.Буяннэмэхийн ялын төлөвлөгөө”-д: “Овог Сономбалжир, нэр Буяннэмэх, нас 37, Улаанбаатар хотын хараат, 3-р хороо, Халх монгол, ард, албан хаагч, бичиг мэдэх, намын гишүүн, урьд Данзаны хэрэгт сэжиглэгдэж нэг сар хоригдсон, баригдахын өмнө Төв театрын уран зохиолчийн ажилтай байсан болой...”(19) гэж тодруулан бичиж байна. Энд “нас 37” гэдэг нь монголчуудын хүний насыг тоолохдоо хуучин насаар нь тоолдог уламжлалт заншлаар тэмдэглэсэн хэрэг, бүхэл насаар нь тоолбол “нас 36” байх ёстой. Энд мөн С.Буяннэмэх 1901 онд төрсөн гэдгийг баттай гэрчилж байна.

Баримт гурав. Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын тусгай архиваас 2007 оны 1-р сарын 22-ны өдөр зохиогч-д хийж өгсөн архивийн лавлагаад “Сономбалжир овогт Буяннэмэх, 1901 онд төрсөн, нас 36 /1937 оны байдлаар/, Өмнөговь аймгийн Дэлгэрхангай сумын хараат, ам бүл 3: эхнэр Халтархүү, түүний эцэг Цэрэн нарын хамт, хөрөнгө: хашаа 1, байшин 1, эсгий гэр 1, өөр хөрөнгөгүй, хотын 3-р хороо, 14-р хорин 259 тоот хашаанд оршин суудаг, театр уран зохиолчийн ажилтай”(20) гэж тодорхойлолт өгчээ. Энэ лавлагаанд Сономбалжирийн Буяннэмэхийн овог нэр, нутаг ус, төрсөн он жил, ам бүл, хөрөнгө хогшил, оршин суугаа хаяг, эрхэлсэн ажил төрөл зэргийг тов тодорхой тушаажээ. “Өмнөговь аймгийн Дэлгэрхангай сум” гэж байгаа нь 1937 оны үед Дэлгэрхангай сум нь Өмнөговь аймагт харьяалагдаж байсан байна. Дараа нь Дундговь аймагт харьяалагдах болжээ.

Баримт дөрөв. 1934 буюу 1935 оны үеэр Монголын үндэсний хувьсгалын уран зохиолчдийн холбооны хэсэг гишүүд хамтран бичсэн “Түмэн ардын төлөөнөө соёлын бүтээлийг бүтээгч”(17) хэмээх зохиолд: “... түүний биеийг зарим хүмүүс дотоод монгол ба зарим нь буриад, зарим нь монгол хэмээн хэлэлцдэг болой. Гэтэл нөхөр Буяннэмэх болбоос Өмнөговь аймгийн Дэлгэрхангайд нутагтай Сономбалжир хэмээх хүний ахмад хөвүүн бөгөөд түүний эцэг нь одоо хүртэл буйн дээр түүний олон дүү нар нь одоо ч байсаар болой. Харин Буяннэмэх болбоос 1901 онд төрж бага наснаасаа эхлэн хэд хэдэн ачтан хүмүүсийн гарыг дамжиж өсч хүмүүжсээр хорь шахам нас хүртэл нэлээд олон аав ээжтэй болсон бөгөөд тэндээс түүний бие хувьсгалт төрийн ачаар өөрийн олон нөхдийн хамт хүмүүжсээр эдүгээ хүрсэн ажгуу”(21) гэж тэмдэглэжээ. С.Буяннэмэхийг улс төрийн хилс хэргээр хэлмэгдэхээс хэдэн жилийн өмнө бичсэн энэхүү зохиолд түүний төрсөн он жилийг “1901” гэж дурайтал тэмдэглэж байгаа нь бидний баримталж байгаа “1902 онд төрсөн бус, харин 1901 онд төрсөн болно” гэх үзэлтийг давхар баталгаажуулж байгаа биш үү.

Баримт тав. С.Буяннэмэхийн ээж Думаагийн охин дүү /С.Буяннэмэхийн нагац эх, Цахар Лувсан буюу Өндөр Лувсангийн эхнэр - зохиогч/-ийн охин Мөнхзул 1962 оны 7-р сарын 8-ны өдөр өөрийн охин Оюунчимэгээр бичүүлсэн “Цогтын Буяннэмэхийн тухай” (22) хэмээх тодорхойлолтоо: “Буяннэмэх нь 1901 онд Түшээт Вангийн хошуунд төрсөн, гарал үүсэл нь малчин, багадаа монгол бичиг бусдаар заалгаж сурсан, орос, хятад хэл суралцсан. Цэнгэлдэх хүрээлэнгийн дарга, Эвлэлийн хороонд чухам ямар ажил хийж явсныг нь мэдэхгүй, Зохиолчдийн бүлгэмийн дарга зэрэг ажил хийж явсан... Мөнхзул би Буяннэмэхийн эхийнх нь эгчийн хүүхэд юм”(23) гэж бичүүлээд, сүүлд нь: “Мэдэхээ тодорхойлсон Лувсангийн Мөнхзул. Би бичиг мэдэхгүй учир өөрийн охин Оюунчимэгээр бичүүлэв. 1962 оны 7-сарын 8-ны өдөр”(24) гэж тэмдэглэжээ. С.Буяннэмэх 5-10 нас хүртэл цахар Лувсан болон Чимэдийн гэр бүлд амьдарч байсан тул тэдний охин Мөнхзултай хамт өссөн байж таарна. Нэг гэрт амьдарч байсан Мөнхзул нь С.Буяннэмэхийн нас жил, түүний өөрөөсөө хэд ах /буюу дүү/ болохыг юун андах билээ.

Иймээс энд тодорхойлсон “Буяннэмэх нь 1901 онд төрсөн” гэдэг нь үнэний үндэслэлтэй чухал баримт болох ажээ. Дагууд нь өгүүлэхэд: Судлагчдийн удаа дараалан бичиж тэмдэглээд байсан өнөөх Чимэд нь Думаагийн охин дүү юу эсвэл эгч нь үү гэдэгт эргэлзэл төрүүлэх болж байна.

Баримт зургаа. Тогтох тайжийн их хүү Дэлгэрийн охин Хаснавчаас 1962 оны 5-р сарын 16-ны өдөр хийсэн “Буяннэмэхийн тухай Хаснавчийн тодорхойлолт”-д: “Буяннэмэх нь 9 настай манайд өргөгдсөн, эх нь монгол, эцэг нь дотор хүн байсан байж магадгүй. Эхийнх нь дүү хүүхэн их ядуу байсан учир түүний нөхөр Лувсан цахар тогтох тайжид үрчлүүлж өгсөн. Бид нар хамт ном үзэж тусгай хөлсний багш Ашингаа гэдэг харчин хүн ном зааж, монгол, манж, хятад хэл зааж, голлон монгол, манж хэл зааж байсан. Гамин орж ирэхэд Лувсан цахар Хиагтад оргуулан авч явсан. Буяннэмэхийг Хиагтад Өлзийдүүрэн гэдэг цахар барьж авч Тогтохын тагнуул гэж гавласан бөгөөд сүүлд тавиад байхад нь ардын засаг үүссэн. Буяннэмэх өөрөө ший дуулж Нацагдорж хамт явж байсан. Буяннэмэх зүрх муутай аймтгай хүүхэд байсан юм. Урдаа хүн гаргахгүй санаатай хүн байсан. Сүүлийн үед архинд орсон боловч гудамжны архичин болоогүй. Нугалгааны үед Тогтох биднийг их шүүмжилсэн учир харилцаа тасарсан. Эхийн дүүгээс гарсан хүүхэн Мөнхзул гэдэг байсан нь одоо амралтад нөхөр Доржийн хамт буй. Буяннэмэх нь багасаа их зантай, олонтой эв муутай, ширүүн харилцаатай хүн байсан”(26) гэж тодорхойлжээ. Хаснавчийн тодорхойлолтод С.Буяннэмэхийн тухай нилээд бодитой гэрч баримтыг мэдээлж байна. Дээр дурдсан энэ хоёр түүхэд их төлөв энэ тодорхойлолтыг ашигласан нь мэдэгдэнэ. “С.Буяннэмэх 9 настай Тогтох тайжийнд өргөгдсөн. Эхийнх нь охин дүү түүний нөхөр Лувсан цахар тогтох тайжид үрчлүүлж өгсөн. Ашингаа гэдэг харчин хүн монгол, манж, хятад хэл зааж, голлон монгол, манж хэл зааж байсан. Гамин Их хүрээнд орж ирэх үед Буяннэмэхийг Лувсан цахар Хиагтад оргуулан авч явсан. Хиагтад Өлзийдүүрэн гэдэг Цахар барьж авч Тогтохын тагнуул гэж гавласан бөгөөд сүүлд нь тавьсан. Нугалгааны үед Тогтохынхныг их шүүмжилсэн учир харилцаа тасарсан. Эхийнх нь охин дүү /Лувсан Цахарын гэргий - зохиогч/-гээс Мөнхзул гэдэг охин гарсан” гэх мэт цөөн бус мэдээг энэ тодорхойлолт хангаж байна. С.Буяннэмэхтэй найм есөн жил хамт өсч, хамт амьдарч, хамт бичиг сурч байсан Хаснавч нь С.Буяннэмэхийн тухай их олон юм мэдэж байсан нь дамжиггүй. Түүний хангасан мэдээ баримт төлөв үнэн баттай, үнэ цэнэ бүхий нэгдүгээр эх материал болох нь яриангүй юм.

Баримт Долоо. Зохиолч Д.Намдаг 1962 оны 9-сарын 22-28-ны өдөр бичиж тэмдэглэсэн “С.Буяннэмэхийн хаалттай явдлууд”(27) гэх зохиолдоо: “... Энэ далимд Буяннэмэхийг сайн мэдэх ураг төрлийнх нь Мядаг хэмээх эмгэний ярьсныг өгүүлсүгэй... Мядаг эмгэн Буяннэмэхийн эхийн эгч мөн бөгөөд түүний өгүүлэх нь: Буяннэмэх хуучин Түшээт хан аймгийн Түшээт гүнгийн хошуу, одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын хүн. Дээр цагт хөрөнгө нимгэнтэй Халх ард Цогт гэдэг хүн таван охин хоёр хүү түрүүлсний нэг болох Думаа мөн хөрөнгө хогшил хомс ард Сономбалжиртай сууж ганц хүү төрүүлсэн нь Буяннэмэх мөн. Таван настай байхад нь эх Думаа нас барж эхийн дүү болох Чимэд гэдэг эмэгтэйд шилжиж ирсэн бөгөөд тэр Чимэд Буяннэмэхийг дагуулан Хүрээ орж Лувсан цахар гэгчтэй суужээ. Өөрийнх нь эцэг Сономбалжирийг Мядаг авгай үзээгүй гэх бөгөөд хойшдоо юу болсныг үл мэднэ. Чимэдээс нэг охин төрөв. Түүний нэр Мөнхзул. Түүнтэй Буяннэмэх хамт нэг гэрт өсөв. Иймд Мөнхзул Буяннэмэхийг сайн мэдэх ёстой бөгөөд Зүүн хараад сууж байв. Суусан хүн нь дээр үед хэвлэлийн хорооны дарга байсан шар Дорж. Тэр Зүүн хараагийн Тарнины амралтад мэргэжлийн тогооч хийдэг. Дээр цагт Буяннэмэхийг Тогтох тайжийнд үрчлэгдэж байсныг үл мэднэ. Би хувьсгалын үйл хэрэгт хэрхэн оролцож явснаас нь тодорхой мэдэх зүйлгүй. Бүх явдлыг шар Доржтой суусан Мөнхзул сайн мэдэх ёстой гэж өгүүлэв”(28) гэж тэмдэглэж байна. Мядаг эмгэний 1962 онд хэлсэн яриа хэдийгээр С.Буяннэмэхийн төрсөн он жилийг тодруулахад баримт болохгүй боловч түүний намтарт байгаа нилээд зүйлийг ариутган тодруулахад чухал

Ван Мандуга

баримт болж байна. Жишээлбэл, С.Буяннэмэхийн ээжийн эцэг халтар Цогт таван охин хоёр хүүтэй. Думаагийн охин дүү /С.Буяннэмэхийг үрчилж авсан нагац эгч - зохиогч/-гийн нэр нь Чимэд, Лувсан цахартай суугаад Мөнхзул гэдэг охинтой болсон. Мөнхзул нь Буяннэмэхтэй хамт нэг гэрт өсч, С.Буяннэмэхийн тухай сайн мэддэг гэх зэрэг баттай мэдээллийг бидэнд хангаж байна. Думаагийн охин дүүгийн нэр нь Чимэд болохыг бид зөвхөн Мядаг эмгэний яриагаас сая мэдэж байгаа билээ.

Дээрх баримт материалуудыг ерөнхийд нь хураангуйлан хянуур ажиглаж үзвэл, зохиолч С.Буяннэмэхийн намтрын анхны хуудас нилээд үнэний мөртэй тодрон гарч байна: “С.Буяннэмэх 1901 онд хуучны Түшээт хан аймгийн Түшээ гүнгийн хошуу, одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Арын булгийн Хүрэн хошуу гэдэг газарт ард халтар Цогтын охин Думаагийн хөвүүн болж заяажээ. Таван настайд нь эх Думаа нас барж, эцэг Сономбалжир амьдрал тусдаа байсан учир, нагац эх Чимэд/Думаагийн охин дүү/ болон нагац эцэг Лувсан цахар хоёрын гэр бүлд амьдарч байгаад 1912 онд 10 настайдаа Өвөр монголын Жирмийн чуулганы Тогтох тайжид үрчлэгджээ. Тогтох тайжийнд байхдаа Тогтох тайжийн их хүү Дэлгэрийн охин Хаснавч, хүү Эрхэмбаяр нартай хамтаар хөлсний багш Ашингаа, Эрдэнэ зэрэг хүмүүсээр монгол, манж бичиг голлон хятад хэл заалгаж сурчээ. Автономитийн үед Их хүрээний дунд сургуульд орж 2 жил шахам монгол бичиг, орос, хятад хэл сурсан байна. 1919 онд Хятадын гамин цэрэг монголд түрэн орж Автономит засгийг устгаж, Их хүрээнд цаг төрийн байдал түгшүүртэй болсонд Тогтох тайжийнхнаас салж нагац эцэг, нагац эхийн хамт Хиагт хотруу явжээ. Хиагтад Өлзийдүүрэн гэдэг цахар барьж Тогтох тайжийн тагнуул гэж гавалсан боловч сүүлээр нь суллан тавьжээ.” Энэ бол С.Буяннэмэхийн төрсөн он, нутаг ус, эцэг эх жич балчир бага насны намтрынх нь нилээд оновчтой бичлэг болох юм.

Зүүлт тайлбар:

- (1) Б.Содном “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв”, Монгол улсын “Шинжлэх ухаан” сэтгүүлийн 1947 оны 13-14 -рт нийтлэгдэв.
- (2) “Сандо Амбаны харгис явдал”- Энэ бол С.Буяннэмэхийн бичсэн “Сандо Амбан” буюу (“Ойрх цагийн товч түүх”) хэмээх жүжгийн зохиол юм. Монгол Улсын Нийтийн номын сангийн монгол бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байгаа 5 дэвтэр гар бичмэл эх. 1922 онд зохиож, 1924 онд дахин зохион бичсэн бичмэл эх.
- (3) “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв” - Энэ бол С.Буяннэмэхийн бичсэн судалгааны томоохон өгүүлэл болно. 1929 оны 12-р сард хувьсгалын уран зохиолч нарын бүлгэмээс хэвлүүлсэн “Уран үгсийн чуулган” хэмээх цоморлогийн 14-69-р нүүрт хэвлэгдэв.
- (4) “Улаан туг” - Энэ бол С.Буяннэмэхийн бичсэн “Шинэ улаан туг” хэмээх дууны шүлэг болно. Энэ дуу мөн дээр дурдсан “Уран үгсийн чуулган” хэмээх цоморлогийн 248-249-р нүүрт хэвлэгдэв.
- (5) Г.И.Михайлов “Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал”, Москва, 1955 оны Орос хэвлэл, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1958 оны монгол хэвлэл.
- (6) (7) (8) (9) (10) (11) (12) (13) (14) Г. И. Михайлов (Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал), Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо, 1958 оны Монгол хэвлэл, 47, 49, 94, 97, 97, 97-98, 99, 189, 289-р нүүрт.
- (15) П.Хорлоо, С.Лувсанвандан, Ц.Мөнх, Д.Цэнд нарын найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх”(1921-1965), Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1968 оны хэвлэл, 175-176-р нүүрт.
- (16) С.Лувсанвандан, Л.Түдэв, Д.Цэдэв нарын найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” тэргүүн боть (1921-1940), Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1985 оны

Ван Мандуга

хэвлэл, 177-р нүүрт.

(17) Г.Зандраабаций эрхэлсэн “Буяннэмэхийг дурсахуй”, Улаанбаатар, Мөнхийн үсэг хэвлэх үйлдвэр, 2002 он.

(18) (19)Архивийн материал.

(20) “Түмэн ардын төлөөнөө соёлын бүтээлийг бүтээгч” (хэсэг гишүүд), 1934 буюу 1935 оны үеэр бичсэн бичмэл эх, Монгол улсын Улсын нийтийн номын санд хадгалагдаж бий.

(21) “Түмэн ардын төлөөнөө соёлын бүтээлийг бүтээгч” (хэсэг гишүүд), Ван Мандуга “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 26-р нүүрт.

(22) (23)(2) Монголын үндэсний төв архивийн хадгаламжид байгаа машиндмал эх.

(25) (26) Г.Зандраабацийгийн эрхэлсэн “Буяннэмэхийг дурсахуй”, Улаанбаатар, Мөнхийн үсэг хэвлэх үйлдвэр, 2002 он. Д.Намдаг “Буяннэмэхийн хаалттай явдлууд”, 23-28-р нүүрт.

(Монгол бичгээс шинэ үсэгт хөрвүүлсэн М.Улаантуяа)